

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
/2010 оны жилийн эцсийн байдлаар/

2011.03.31

№	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээний	
			хувь	оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	92,2	4,61
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	66,9	3,34
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	85,0	4,25
Үнэлгээний дундаж оноо			81,37	4,07
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	91,6	4,58
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	89,0	4,45
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	99,1	4,95
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	85,6	4,28
Үнэлгээний дундаж оноо			91,33	4,57
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	91,3	4,57
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	80,0	4,00
Үнэлгээний дундаж оноо			85,65	4,28
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	99,8	4,99
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	87,5	4,37
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	95,7	4,78
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	99,0	4,95
Үнэлгээний дундаж оноо			95,50	4,78
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	81,4	4,07
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	69,0	3,47
Үнэлгээний дундаж оноо			75,20	3,76
Ерөнхий үнэлгээ			85,81	4,29

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ТАСГИЙН ДАРГА Г.ХАНДАРМАА

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Аймгийн Засаг даргын 2011 оны а/124 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын 2010 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ хяналт шинжилгээ хийх ажлын өлөвлөгөөг аймгийн ЗДТГ -ын даргаар батлуулан 2010 оны үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэл гаргасан баримт бичгийг судлах, түүнд хяналт шинжилгээ хийх, шаардлагатай нэмэлт мэдээлэл цуглуулж боловсруулах журмаар ажиллалаа.

Нэг. Байгууллагын үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь өнгөрсөн 2010 онд Монгол улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын өрийн хөтөлбөр, төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган билүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж төрийн албаны стандартыг хангуулах, өрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, үр дүнд суурилсан хяналт шинжилгээний чадавхыг бэхлэх, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнд дээшлүүлэх, хариуцлага, сахилгыг өндөржүүлэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж ирсэн байна.

Тус байгууллага нь Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор баталсан орон тоо бүтцийн жишгийн дагуу 5 хэлтэс, 1 штабын зохион байгуулалттай, 38 орон тоотойгоорүйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын албан хаагчдын 71,0 хувь нь дээд, 5,2 хувь нь тусгай дунд, боловсролтой, 23,6

хувь нь магистер байна. Албан хаагчдыг үбцээр нь авч үзвэл: эрэгтэй 14, эмэгтэй 24 хүн, насны хувьд 20-25 насны 5, 26-35 насны 14, 36-45 насны 8, 46-55 насны 11, дундаж нас 35 байна. Мэргэжлийн хувьд хуульч эрх зүйч 7, эдийн засагч, нягтлан бодогч 10, багш 5, инженер 2, эмч 2, ХАА-н мэргэжилтэн 2, бусад мэргэжлийн хүн 10 байгаа ба төрийн албанд 1-5 жил 14, 6-10 жил 6, 10-15 жил 3, 16-аас дээш жил 14 хүн тус тус ажиллаж байна.

Байгууллагын ерөнхий менежер эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчтай, нэгжийн менежер /хэлтсийн дарга/-үүд байгууллагын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраар төрийн үйлчилгээ эний ил тод, нээлттэй шуурхай байдлыг хангах чиглэлээр улс, аймгийн хэвлэл мэдээллийн 10 байгууллагатай гэрээ байгуулан тэдний үйл ажиллагааг дэмжиж ажилласны зэрэгцээ аймгийн хэмжээнд “Ил тод байдал-чанартай үйлчилгээ” 2 сарын аян зохион байгуулж дүгнэсэн нь төрийн үйлчилгээний нээлттэй, ил тод, шуурхай, хүртээмжтэй байх нөхцлийг хангахад үр дүнгээ өгч байна.

Аймгийн төвийн бүх төрийн байгууллага интернет, дотоод сүлжээгээр, 8 сум шилэн кабельд холбогдсон нь удирдлагын мэдээллийг цахим хэлбэрээр авах боломж бүрдэж байгаагийн дээр. Өмнөговь аймгийн Вэб хуудсыг Засгийн газрын Вэб сайтад байрлуулж, энэ хугацаанд Вэб сайтад 27730 иргэн зочилсон байгаа нь иргэд төрийн мэдээллийг шуурхай авах боломжийг бүрдүүлж байна.

Бодлогын болон байгууллагын хяналт шинжилгээний үр дүн, үр нөлөөг сайжруулах зорилгоор хяналт шинжилгээ үнэлгээний байнгын ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан агентлагийн хяналт шинжилгээ хариуцсан ажилтнууд болон ИНБ-ын төлөөлөл оролцуулан зохион байгуулж хяналт шинжилгээ, үнэлгээний бодитой, шударга байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна..

Аймгийн Засаг даргаас гарах шийдвэрийн үндэслэлийг сайжруулах, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох зорилгоор аймгийн Засаг даргын өвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн шаардлагатай салбарын мэргэжлийн удирдах албан тушаалтан, ИНБ-ын өлөөллийг оролцуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын өвлөл 7 удаа хуралдаж аймаг орон нутгийн тулгамдсан болон цаг үеийн 50 ажил асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний зэрэгцээ Тамгын газрын аппаратын болон удирдах

ажилтны шуурхайг сар үр хийж мэдээлэл солилцох, удирдлага зохицуулалтаар хангах зэргээр хамтын ажиллагааг уялдуулан ажиллаж иржээ.

Хоёр. Ажилд гарч буй ололт, амжилтын талаар

2,1 Эдийн засгийн бодлогын хүрээнд

2010 онд өсвийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төсвийн орлогын бололцоотой бүх эх үүсвэрийг бүрэн дайчлах, оновчтой хуваарилан үр өгөөжтэй ашиглах арга хэмжээг авч, бүх төрлийн татвар, төлбөр хураамжийг бүрэн ногдуулж, хураах, түүнд тавих хяналтыг сайжруулах, татварлах нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэх зорилтуудыг тавьж хэрэгжүүлснээр зохих амжилтанд хүрч байна.

Өнгөрсөн 2010 онд орон нутгийн төсвийн орлого 40858,3 сая төгрөгт хүрч, төсвийн орлогын төлөвлөгөө 6048,1 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар дутуу төвлөрч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 16.0 тэрбум төгрөгөөр буюу 64.5 хувиар өсч, аймгийн өөрийгөө санхүүжүүлэх чадавхи 394.9 хувьд хүрч, өнгөрсөн оноос 213.8 хувиар нэмэгдсэн байна.

ТБУСТХууль хэрэгжиж эхэлсэн 2003 онд орон нутгийн төсвийн орлого 735.2 сая төгрөг байсан 7 жилийн өмнөх хугацаатай харьцуулахад төсвийн орлогын хэмжээ 40.2 тэрбум төгрөгөөр буюу 55,6 дахин өссөн нь аймгийн эдийг засаг, төсөв, санхүүгийн чадавхи асар хурдтай нэмэгдэж, орон нутгийн төсвийн бие даасан байдал хангагдвал аймаг хөгжих бүрэн боломжтой байгааг харуулж байна.

Урсгал орлого 40785,4 сая өгрөг, түүний дотор татварын орлого 31710.1 сая төгрөгт хүрч урсгал орлогын 77,7 хувь, татварын бус орлого 9075.3 сая төгрөгт хүрч урсгал орлогын 22,3 хувь, хөрөнгийн орлогоор 72.9 сая төгрөг төвлөрсөн байна.

Төсвийн давсан орлогыг нэр төрлөөр авч үзвэл:

Хүн амын орлогын албан татварын орлого 4756,8 сая төгрөгт хүрч, 5.7 хувиар буюу 260.6 сая төгрөгөөр

Өмчийн татвар 424,7 сая төгрөгт хүрч, 49.3 хувиар буюу 140.2 сая төгрөгөөр

Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 874,8 сая төгрөгт хүрч, 16.6 хувиар буюу 124.8 сая төгрөгөөр

Татварын бус орлого 9076,0 сая төгрөгт хүрч, 2.2 хувиар буюу 198.8 сая төгрөгөөр

Хөрөнгийн орлого 72,9 сая төгрөг хүрч, 16.6 хувиар буюу 10.4 сая өгрөгөөр тус тус давж биелэгдсэн байна.

Харин бусад татвар хураамжийн орлогод 25707,8 сая өгрөг төвлөрч, 6782.8 сая төгрөгөөр буюу 20.9 хувиар тасалдсаны дотор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 18357,3 сая төгрөг болж, батлагдсанаас 8918.1 сая төгрөгөөр буюу 32.8 хувиар тасалдсан байна.

Дээрх орлогын тасалдлын шалтгаан нь Сангийн яамнаас төсвийн тодотголоор хувьцааны ногдол ашиг 7872,6 сая өгрөг байхаар байтал үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 20176,4 сая төгрөгөөр тооцсоны зөрүүг нөөцийн төлбөрийн орлого дээр нэмж тодотгосонтой шууд холбоотой байна.

Орон нутгийн төсвийн орлогын дүнд уул уурхайн салбараас орж байгаа ашигт малтмалын нөөцийн төлбөрийн орлого 44.8 хувийг, тусгай зөвшөөрлийн орлого 8.9 хувийг, ногдол ашгийн орлого 19.2 хувийг эзэлж байгаа ба дээрх орлогууд нийт орлогын дүнд 72.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 10.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар:

2010 онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлэг 31259,2 сая төгрөг болж, улсын төсвийн өмнө хүлээсэн үүргээ 84,5 хувийн амжилттай биелүүлжээ.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтэнд 10345,8 сая төгрөгт хүрч, батлагдсан зардлыг 554.9 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар хэмнэсэн байна.

Нийт зардлын дүнд урсгал зардал 4854.5 сая төгрөг буюу 11.7 хувь, хөрөнгө оруулалтын зардал 5491.3 сая өгрөг буюу 13.2 хувь, улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлэг 75.1 хувийг эзэлж байна.

Улсын төсөвт 47,7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 40.9 тэрбум төгрөг нийт 88,6 тэрбум төгрөг төвлөрүүлж, улсын төсвийн байгууллагууд 15,4 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 10,3 тэрбум төгрөг, нийт 25,7 тэрбум төгрөг зарцуулагдсанаас үзэхэд бүрдүүлсэн орлогоороо аймаг өөрийгөө буюу улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудыг бүрэн санхүүжүүлэх боломжтойг харуулж байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг нэр төрлөөр авч үзвэл:

-Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар 360.0 сая төгрөг төвлөрүүэхээс 408.8 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 113.6 хувиар

Нэмэгдсэн өртгийн албан та тварт 750.0 сая өгрөгийн орлого төвлөрүүлэхээс 908.0 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 121.1 хувиар

-Онцгой албан татвараар 77.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар,


-Тусгай зөвшөөрлийн орлогоор 3640.3 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувиар тус тус биелүүлжээ.

Харин ашигт малтмалыооц ашигласны төлбөрийн орлогоор 42707.7 сая төгрөг төвлөрүүлжээ


Улсын төсвийн байгууллагын зарлагад 2010 онд 15603.8 сая төгрөг зарцуулахаас 15369.4 сая төгрөг зарцуулж, төсөвт зардлыг 234.4 сая төгрөгөөр букуу 1.5 хувиар хэмнэсэн ба өнгөрсөн онтой харьцуулахад төсөвт зардал 2633.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна

Аймгийн эдийн засгийн үзүүлэлтүүдээс:


Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэлийн динамик үзүүлэлт \сая,төг\




Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 2008-2009 он \сая,төг\





Аймгийн өөрийгөө санхүүжүүлэх чадавх /хувиар/



Орон нутгийн төсвөөс улсын орлогод төвлөрүүлсэн орлого /2007-2010/сая,төг





Хөрөнгө оруулалт, их засварын зардлаас улсын төсвийн байгууллагуудад тухайлбал: боловсролын салбарт 299.9 сая төгрөг, Эрүүл мэндийн салбарт 574.5 сая төгрөг, Цагдаа, зэвсэгт хүчний байгууллагуудад 328.1 сая төгрөг, Нийтийн ерөнхий үйлчилгээнд 1935.2 сая төгрөг, дэд бүтцийн салбарт 765.8 сая төгрөг, бусад салбарт 604.1 сая төгрөг тус тус зарцуулж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засварын зардалд 2010 онд нийт 5491,3 сая төгрөг зарцуулсан нь жилийн нийт зардлын 53.1 хувьтай тэнцэн, өнгөрсөн оноос 1469.9 сая төгрөгөөр нэмэгджээ.

Орон нутгийн төсвийн нийт зардалд хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь төсвийн зарлагын үр өгөөжийг дээшлүүлж, бүтээн байгуулалтын талаар тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэд тус дөхөм болж байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний талаар:

Тус аймагт уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан “Уул уурхай эрхлэгчдийн зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг”-ийг жил бүр зохион байгуулж, харилцан хамтын ажиллагааг хангаж ажиллах үүрэг зорилго бүхий төр хувийн хэвшил, ИНБ-ын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ажиллуулан, “Өмнөговийн хөгжлийн сан”-г шинээр байгуулан уул уурхайн компаниудын ашиг орлогын зарим хэсгийг орон нутгийн хөгжил, хүн ардын сайн сайхан амьдралын төлөө зарцуулж эхэлсэн нь тэдний нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр өсөн нэмэгдэхэд түлхэц болж байна.

Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлтийн ажилд ахиц гарч, Оюу-толгой төслөөс “Ургамлын мониторинг”-ийн талбайг бий болгон тухайн бүс нутгийн унаган ургамлын үрийн нөөц сантай болж,

“Энержи ресурс” ХХК мод үржүүлгийн 2,5 га талбайг шинээр бий болгон говийн нөхцөлд ургадаг 9000 ширхэг тарьц суулгацыг туршин ургуулж байгаа, “Олон-Овоот гоулд” ХХК хүлэмж байгуулан 4 төрлийн бутлаг ургамлыг суулгаж, 208 га газарт загийн үрийг тарьж туршилт хийсэн нь үр дүнтэй болж, тарьц суулгацын амьдралт 91%-тай, үрээр тарьсан загны өсөлт 15-20 см байна.

2010 оны 10-р сарын байдлаар тус аймгийн нутаг дэвсгэрийн талбайн хувьд хайгуулд 6556.0 мянган га, ашиглалтанд 275.0 мянган га, нийтдээ 6.8 сая га талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдож нийт нутаг дэвсгэрийн 41.2 %-ийг эзэлж байгаа нь хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт сөргөөр нөлөөлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэрлэлийн талаар:

Энэ онд аймгийн хэмжээнд аж үйлдвэрлэлийн салбарт 321,6 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 354,9 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өнгөрсөн оноос бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2,2 дахин буюу 176,9 тэрбум төгрөгөөр, борлуулалт 2,0 дахин буюу 178,5 тэрбум сая төгрөгөөр өссөн нь уул уурхайн хөгжлийг даган зах зээл нэмэгдэж, жижиг дунд үйлдвэрлэл хөгжиж байгааг харуулж байна.

Хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор аймгийн төвд жилд 2,2 мянган тонн мах боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, 400 тонн мах, махан бүтээгдэхүүн, 600 тонн хүнсний ногоо, жимс хадгалах орчин үеийн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний агуулах, 60 га усалгаатай талбайд тэжээлийн эрдэнэшиш тарих, 100 мэжтэй гахайн аж ахуй байгуулах махны үйлдвэрийн цогц төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулсан бөгөөд махны үйлдвэр барих ажлын хөрөнгө оруулагчийг шалгаруулахаар төслийн уралдаан зарлагдаад байна.

Хүнсний аюулгүй байдал” 3 сарын аяны хүрээнд хүнсний аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн дунд хугацаат цом, дэвтэр аялуулан үйл ажиллагааг сурталчилсан нь тэдний идэвх санаачилгыг өрнүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, хоршоо нөхөрлөл байгуулах замаар мал аж ахуйн хамтын хөдөлмөрийг дэмжин урамшуулах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйдвэрлэлийг дэмжихэд аймаг орон нутгийн бодлого үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж, 2010 онд Ингэний айрагны баяр -2010, ХАА-н удирдах ажилтны зөвлөгөөн, Хүнсний аюулгүй байдлын аян, Говь фестиваль-2010 зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, ган зудын улмаас малгүй болсон малчин өрхийг малжуулах төслийг хэрэгжүүлж 418 өрхөд орон нутгийн хөрөнгөөр 342,7 сая төгрөг зарцуулсан байна. Аймгийн “Малчдын зөвлөгөөн”-ийг 6 дугаар сард зохион байгуулж,

зөвлөгөөнд 15 сумаас нийт 150 малчин оролцож Өмнөговь аймгийн мал аж ахуйн салбарын цаашдын хөгжлийн талаар хэлэлцэн, аймгийн “Малчин” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ болжээ.

“Их говийн экологи ба монгол тэмээ” сэдэвт ОУ-ын симпозиум 2010 оны 10 дугаар сард болж хоёрөвт тэмээний аж ахуйн онцлог, өнөөгийн байдал болон цаашдын зорилт, эдийн засгийн ач холбогдол, тэмээний аж ахуйн үзэгдэхүүн, түүхий эдийн ач холбогдлыг судалсан гадаад дотоодын мэргэжилтнүүдийн судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн бүтээлүүдийн илтгэл мэдээлэл, нээлттэй ярилцлага зохион байгуулж, цаашид ОУ-ын түвшинд болон УИХ, Засгийн газрын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргасан байна. Сүүлийн 2 жилийн өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой малын тоо 1010327 болж өнгөрсөн оныхоос 744888 толгой малаар хорогдсон, малчин өрхийн тоо 5628 болж 673 өрхөөр буурч, 1300 гаруй өрх нийт мал сүргийнхээ 50-иас дээш хувийг хорогдуулсан нь малчдын амьжиргааны түвшин, аймгийн эдийн засгийн салбарт ихээхэн хохирол учруулж байна.



Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах зорилгоор 2010 онд 50 га талбайд шинээр ойжуулалт, 50 га талбайд нөхөн сэргээлт, тарьц суулгаж, 2007-2009 онд гэрээгээр мод тарьж ургуулсан иргэдийн гэрээний хэрэгжилтэнд ИНБ-тай хамтран хяналт хийж, нийт 81,2 мянган модонд, 151,1 сая төгрөгийн урамшууллыг олгож, байгаль орчныг хамгаалахад иргэдийн санаачлагыг дэмжин бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулан 97367 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 79419 ш модыг тарьсан нь улсын хэмжээнд хамгийн их мод тарьсан аймаг боллоо.

Цэвэр сортын үрийн төмсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 15 сумын газар тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн захиалга, хүсэлтийн дагуу Голланд улсын Импала сортын үрийн төмс 11 тонн, монгол сортын үрийн төмс 18,0 тонныг Төв аймгийн Жаргалант сумаас татан авч олгон төмс хүнсний ногооны үрийн хангамжийг өнгөрсөн жилээс 13.7 хувиар нэмэгдүүлсэн байна.

2.2 Төрийн захиргааны бодлогын хүрээнд

Тайлант хугацаанд “Иргэдэд үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага сахилгыг өндөржүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэд олон нийтийн

оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, төрийн байгууллагын хүнд суртлыг арилган, иргэн бүрт хүрсэн тэгш үйлчилгээг бий болгох” зорилт тавин ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн аймгийн хэмжээний бүх төсвийн байгууллагуудын дунд “Ил тод байдал-чанартай үйлчилгээ” 2 сарын аяныг зохион байгуулж дүгнэснээр төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, хүртээмжтэй, шуурхай байдлыг хангах ажилд ахиц дэвшил гарсан байна.

Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлэхэд анхаарч төрийн байгууллагуудын “Сахилга хариуцлагын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, төсвийн сахилга, төрийн албаны стандарт хангалт, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар хэлэлцэж, албан даалгавар гарган хэрэгжүүллээ.

Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт”, “Нутгийн хишиг хөтөлбөрийн олголт”, “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт” зэрэг төрийн зарим ажил үйлчилгээнд мониторинг хийлгүүлж, аймгийн хэмжээнд тарьсан модны тооллого судалгааны ажил, Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу төрийн үйлчилгээнд хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж, гарсан үр дүн шийдвэрт үндэслэн цаашдын бодлого үйл ажиллагаагаа төлөвлөх, бодлого шийдвэрийн хэрэгжилт үр дүнд дотоодын хяналт шинжилгээ хийх ажлыг өргөжүүлэн ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр бүх үнэлгээний хороодод ИНБ-ын төлөөлөл оруулж, “Үдийн цай төсөл” эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Ээлтэй эмнэлэг” төсөл, байгаль хамгаалах малчны нөхөрлөл байгуулах “Хамтын хүч” төсөл болон нэн ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байртай болгох “Бүлгийн төсөл” зэрэг төсөл хөтөлбөрийг иргэний нийгмийн байгууллагаас санаачлан хэрэгжүүлсэний зэрэгцээ олон төрлийн сургалт арга хэмжээг зохион байгуулж ажилласан нь төрийн зарим ажил үйлчилгээг захиалга гэрээгээр гүйцэтгэх ажилд ахиц гарч, үр дүнгээ өгч байна.

2010 онд “Уур амьсгалын өөрчлөлт”-ийн асуудлаар Монгол улсын Засгийн газрын хуралдаан анх удаа Өмнөговь аймагт хуралдаж, Төвийн бүсийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, Их говийн экологи ба Монгол тэмээ” олон улсын симпозиум зэрэг томоохон арга хэмжээнүүд болж өнгөрсөн нь орон нутгийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

Хэрэглэгчийн үнэлгээ авах санал асуулгын 3,4,1-д аймгийн ЗДТГазрын үйл ажиллагаанд та үнэлгээ өгнө үү? гэсэн судалгааны дүнгээр иргэд 3,50 оноо өгсөн нь урьд оноос 0,1 хувиар нэмэгдсэн байгаа нь аймгийн ЗДТГазарт хандах иргэдийн хандлага өсч байгааг харуулж болохоор байна.

2.3 Нийгмийн бодлогын хүрээнд

Нийгмийн салбарын хүрээнд 2010 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг иргэдэд ойртуулах, мэдээлэл сурталчилгааны ажлыг сайжруулж, ажлын байрны захиалга, шинээр бий болсон ажлын байр, сургалт, нийтийг хамарсан ажлууд, ХЭДСангаас олгож буй ажлын байр нэмэгдүүлэх хөнгөлөлттэй зээлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран иргэдэд тогтмол хүргэн ажилласнаар жилийн эцсийн байдлаар 1248 иргэнийг улсын салбарын болон хувийн хэвшлийн байгууллагад шинэ болон сул ажлын байранд зуучилж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг 384 иргэнд үзүүлж, тэдний 60-аас доошгүй хувийг ажлын байртай болгожээ.

2010 онд 1241 шинэ ажлын байр бий болгосон боловч аймгийн хөдөлмөрийн зах зээлд ажил идэвхтэй хайж байгаа 926 хүн байгаа нь бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн тоо өмнөх оноос 472 хүнээр нэмэгдсэн дүнтэй байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Оюу толгой, Таван толгой ХХК, Энержи Ресурс ХХК, Монгол Алт ХХК, Транс говь ХХК зэрэг уул уурхайн компаниуд хамгийн олон шинэ ажлын байрыг бий болгож байгаа хэдий ч орон нутгаас ажилчин авч ажиллуулах, орон нутгийн төрийн байгууллагатай хамтран ажиллах талаар хангалтгүй ажилласан байгаатай холбоотой гэж үзэж байна.

Мэргэжлийн сургалт явуулах зөвшөөрөл авсан эрх бүхий сургалтын байгууллагуудтай хамтран уул уурхай, барилга болон техникийн үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, бусад мэргэжлийн сургалтанд ажил идэвхитэй хайгч, хөдөлмөрийн биржид байнгын бүртгэлтэй иргэдийг хамруулан, мэргэжил олгох давтан сургалтанд 384 иргэнийг суралцуулж, чадамжийг тодорхойлох гэрчилгээг олгон цаашид ажлын байртай болох нөхцөл бололцоо бий болгож нийтийг хамарсан 38 удаагийн ажлыг зохион байгуулж, ажилд 682 иргэнийг ажиллуулж түр ажлын байраар хангасан байна.

Эрүүл мэндийн салбарын чиглэлээр хөдөө сумдад ажиллах мэргэжилтэй боловсон хүчний хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Эмчийн орон сууц хөтөлбөр”, “Эмчийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр Цогт-овоо, Хүрмэн сумдад эмчийн 2 айлын орон сууцыг барьж ашиглалтанд оруулж,

Орон сууц санхүүжилтийн корпорацитай хамтран 11 эмч мэргэжилтнийг орон сууцаар ханган, 14 эмч мэргэжилтнийг тэтгэлэгт хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулсан байна..

Энэ онд шинээр 22 эмч мэргэжилтэнүүдийг сургалтанд хамруулж, тэдний мэдлэг мэргэжлийг тогтмол дээшлүүлэх бодлого баримталж ажилласны дүнд сүүлийн жилүүдэд энэ тоо тогтмол өссөн дүнтэй байгаа нь тэднийг чадавхижуулах, улмаар эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна.

2010 онд аймгийн хэмжээгээр 1085 хүүхэд мэндэлж, 292 хүн нас барсан нь урьд оноос төрөлт 6,2 хувиар буурч, нас баралт 6,5 хувиар өссөн байна. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 26, 1-5 насны хүүхдийн эндэгдэл нь 4, эхийн эндэгдэл 2 гарсан байна. Харин хурц халдварт өвчин 128 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 8 хүнээр өссөн, гепатит өвчин 31 гарсан нь 0,9 хувиар буурсан байна.

Мөн орчин үеийн дэвшилтэт эмнэлгийн болон лабораторийн тоног төхөөрөмж, эмнэлгийн түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт, материаллаг баазыг нэмэгдүүлэх хүрээнд 890,5 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг хийснээр эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, нялхасын эндэгдэл 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 1,1 промилиор буурсан, халдварт өвчин улс, аймгийн дундажаас буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын орлогын төлөвлөгөөний биелэлт 0,5 хувиар буюу 27,8 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар нийт тэтгэвэр авагчдад 5,69 тэрбум төгрөгийн тэтгэврийг тавьж олгон, сайн дурын даатгалд 1056 хүн хамруулсан байна.

Боловсролын салбарын хувьд 2009-2010 оны хичээлийн жилд 18 ерөнхий боловсролын сургуульд 10429 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролын 18 байгууллагад 2585 хүүхэд хүмүүжиж, МСҮТөвд 644 сурагч суралцаж, нийт 522 багш ажиллаж байна.

2009-2010 оны хичээлийн жилд 11-р ангийг 515 сурагч амжилттай төгсч, их дээд сургуулиудын консерциумаас ирүүлсэн хуваарийн дагуу 372 сурагч шинээр их дээд сургуульд элсэн орж, 2010-2011 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 10516 сурагч, үүнээс 6 настны 1-р ангид 985 хүүхэд суралцахаар болоод байна.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын стандарт хангалтыг нэмэгдүүлэх, сургалтын арга хэлбэрийг орчин үеийн өндөр хөгжилтэй орнуудын туршлага, үндэсний зан заншил, онцлогт тохируулан хүүхэд төвтэй сургалтад ойртуулах бодлого баримтлан ажиллаж ирсэний үр дүнд 2009 – 2010 оны хичээлийн жилд стандарт хангалт – 93,2 хувь, АВС-ийн эзлэх хувь 53,2 хувьд хүрчээ.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтанд нийт 3308 хүүхэд хамрагдахаас 2585 хүүхэд хамрагдаж 78.1 хувь, суурь боловсролын хамран сургалтанд нийт 4079 хүүхэд хамрагдахаас

3893 хүүхэд хамрагдаж 95.4 хувьд тус тус хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулж үзвэл сургуулийн өмнөх боловсрол 2.7 хувиар, суурь боловсрол 5.1%-иар тус тус ахисан байна.

Аймгийн хэмжээнд бичиг үсэггүй нийт 231 иргэдийн 118 иргэн бичиг үсгийн боловсролд хамрагдаж, 67 хүн буюу 29 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

Аймгийн хэмжээнд 2009-2010 оны хичээлийн жилд нийт 522 багш ажиллаж байгаа бөгөөд багшийн хангалт 97,9 хувьд хүрсэн нь өмнөх оноос 9,8% ахисан байна.

2010-2011 хичээлийн жилд “Нэгж хичээлийн үр өгөөжийг дээшлүүлье” зорилгын хүрээнд 20 зорилтыг дэвшүүлж багш нарын бага хурлаар хэлэлцэж баталж хэрэгжүүлж иржээ.

Бүх сургуулийн хичээлийн эрхлэгч нарыг гадаадын өндөр хөгжилтэй орны туршлага судлуулах ажлаар Сингапур, Малайз улсад аялуулан туршлага судлуулсан нь тэдний идэвх санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дээшлүүлэхэд нөлөөлж байна.

Аймгийн Засаг даргын санаачилгаар амьжиргааны түвшин доогуур айл өрхүүдийн хүүхдүүдийн сурах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 5,7 сая төгрөгийг зарцуулан, 200 хүүхдийг хичээлийн хэрэгслээр хангасан байна.

Соёл урлагын салбарын хувьд Монгол хүнийг бүх талаар хөгжүүлэх, Соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал, шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан хамгаалах, бататган хөгжүүлэх замаар үндэснийхээ соёлын дэлхийн соёлд эзлэх байр суурийг нь бэхжүүлэх, соёл, урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, оюуны өмчийг хамгаалах бодлогын хүрээнд иргэдийн оюуны хэрэгцээг хангах, соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, аймгийн нийт хүн амын 75%-д хүрч үйлчилсэн байна. Мөн аймгийн хэмжээний “Соёлын өв, түүх соёлын үл хөдлөх дурсгал” ын судалгааг хийх ажлыг мэргэжлийн хүмүүсийн баг ажиллуулан зохион байгуулж, зурагжуулан баримтжуулжээ.

Соёл, урлагийн ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх тэдний ур чадварыг сайжруулан ХЖТ-ын бүх уран бүтээлчдийг СУИСургуулийн мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтанд хамруулан, 3 залуу уран бүтээлчийг гадаадын өндөр хөгжилтэй оронд уран бүтээлээ туурвихад дэмжиж, орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөгний санхүүжилтийг олгож ажилласнаар мэргэжилтэй боловсон хүчний тоо өмнөх оноос 14%-иар нэмэгдсэн байна.

Орон нутгийн зохиогч яруу найрагчдыг дэмжиж, тэдний бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хүрээнд аймгийн хэмжээнд тойрон аялалыг зохион байгуулахын зэрэгцээ орон нутгийн төсвөөсөө 3,0 сая төгрөгний санхүүжилтийг хийж, сумдын номын сангуудын фондыг баяжуулсан байна.

Соёл, урлагийн байгууллагуудын барилга, материаллаг бааз, хөгжим техник хэрэгслэлийг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд аймгийн ХЖТ-ын барилга, Музейн барилга зэргийн зураг төслийг боловсруулан хүлээж аваад байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэврэй сумдад соёлын төвийн барилгын барилга угсралтын ажил хийгдэж байгаа бөгөөд Мандал-овоо, Цогт-овоо сумдад соёлын төвийг барьж ашиглалтанд оруулан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Номгон, Манлай сумдын соёлын төвийг иж бүрэн хөгжим техник хэрэгслэлээр хангасан байна.

Гурав. Үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар

3.1 Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар

Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, тогтоол шийдвэрийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн хэтийн болон дунд хугацааны бодлого, цаг үеийн үйл ажиллагааны төлөвлөлттэй нягт уялдуулан хэрэгжүүлж байгаа нь төрийн бодлого шийдвэрийг орон нутагт амжилттай хэрэгжүүлж аймаг, орон нутгийн хөгжлийг хангах, ард иргэдийнхээ ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал алхам болж байна.

Тайлант онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Хүмүүнлэгийн” хөтөлбөр, “Малчин” хөтөлбөр, “Хүнсний баталгаат байдал” зэрэг бодлогын дунд хугацааны хөтөлбөрийг өнөөгийн шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор уулзалт, зөвлөгөөн зохион байгуулан хэлэлцүүлж, батлан мөрдөж байна.

Аймгийн хэмжээнд Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХурал болон Тэргүүлэгчдийн хурлаас батлан гаргасан 34 аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж хагас бүтэн жилээр явц, үр дүнг хэлэлцэн эрчимжүүлж ажилласнаар 2010 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 72,6 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Аймгийн Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд 2010 онд 729 захирамж, 7 албан даалгавар гарган орон нутгийн цаг үеийн болон тулгамдсан ажил асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлж, явц, үр дүнг улирал бүр дүгнэн ажилласнаар нийт захирамж 92,0 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

3.1.1 Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Монгол улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д ззасан стратегийн зорилтуудаас орон нутгийн удирдлагаас хамтран хэрэгжүүлэхээр 6 тэргүүлэх чиглэлийн хүрээнд тусгагдсан 119 стратегийн зорилтыг түүвэрлэн авч, хэрэгжилтийг тооцсон байна.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт 122 заалт, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 225 заалтын хүрээнд үндэсний цогц бодлогын зорилт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэнээр тухайн жилийн зорилт биелэлт 92,2 хувьтай биелэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re2.doc/-оос танилцах

3,1,2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орон нутгийн удирдлагаас хамтран хэрэгжүүлэхээр заагдсан 96 зорилтын хүрээнд багтах 161 заалтыг хяналтанд авч, эзэнжүүлэн хэрэгжилтийг тооцож ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу үнэлгээ өгч үзэхэд 2010 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр дунджаар 66,5%-тай хэрэгжиж байна.

Хөтөлбөрт Өмнөговь аймгийн Засаг даргаас хамтран хэрэгжүүлэх нийт 161 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 2009 онд хэрэгжиж дуусах 7 арга хэмжээ, 2009-2010 онд хэрэгжүүлж дуусах 17 арга хэмжээ байгаа нь нийт арга хэмжээний 15,4 хувийг эзэлж байгаа бөгөөд дээрхи арга хэмжээний дундаж хэрэгжилт 66,9 хувьтай байна.

2009-2010 онд хэрэгжиж дуусах 17 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 1 заалт бүрэн биелж, 5 заалт 90 хувьтай, 5 заалт 70 хувьтай, 4 заалт 50 хувьтай, 2 заалт 30 хувьтай хэрэгжиж байна.

Хэрэгжилтийн явцаас харахад дээд байгууллагаас баталж гаргах дүрэм журам, арга зүйн баримт бичгүүд хугацаандаа батлагдаж гараагүй байгаатай болон хөрөнгө санхүүгийн эх үүсвэр байхгүйтэй холбоотой өнгөрсөн 2 жилийн хугацаанд хэрэгжиж дуусах байсан 18 заалт дутуу хэрэгжиж, 2 заалт тасарсан байна.

Мөн батлагдаж ирж байгаа хөтөлбөр төлөвлөгөө тусгагдсан хөрөнгө санхүүгүй, хөрөнгө батлагдс а ч тэр нь хөдөө орон нутагт ирдэггүй, хөтөлбөрийг орон нутагт ямар байдлаар

хэрэгжүүлэхийг тодорхой нарийвчилж зааж өгөхгүй байгаагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл учирч байна

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re3.doc/-оос танилцах

3,1,3 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Засгийн газраас батлагдсан 2010 онд хэрэгжиж байгаа 88 үндэсний хөтөлбөрийг хяналтад авч биелэлт, үр дүнг улирал бүр тооцон дүгнэж, эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар тайлант оны жилийн эцсийн байдлаар 85 хувьтай хэрэгжсэн байна.

Хөтөлбөрүүдийг авч үзвэл: төрийн захиргаа, хууль хяналтын салбарын хүрээнд 19 хөтөлбөр 84,0, Хөгжлийн бодлого, байгаль орчин аялал жуулчлал, газрын харилцаа барилга, орон нутгийн өмчийн хүрээнд 36 хөтөлбөр 84,0, Нийгмийн хөгжлийн салбарын хүрээнд 33 хөтөлбөр 85,0, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн хүрээнд 11 хөтөлбөр 57 хувийн биелэлттэй хэрэгжих байна. Аймгийн хэмжээнд дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 449,9 сая төгрөгийн хөрөнгө гарган шийдвэрлэсэн дүнтэй байна.

Хэрэгжилтийн дүн мэдээнээс харахад батлагдаж байгаа ихэнх хөтөлбөрүүд хөрөнгө санхүүжилт байхгүй байгаа нь хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаагийн дотор 9 хөтөлбөр хөрөнгө санхүү, зохион байгуулалт, орон нутгйн хэмжээнд хэрэгжих боломж нөхцлөөс шалтгаалан удаашралтай хэрэгжиж байна.

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re4.doc/-оос танилцах

3,2 Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын талаар

3,2,1 Үндсэн чиглэлийн хэрэгжилт

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2010 оны чиглэлийн хүрээнд аймгийн Засаг даргаас хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны 69 заалтыг хяналтад авч аймгийн эдийн засаг нийгмийн хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг улирал бүр тооцож ажилласнаар төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу дүгнэж үзэхэд 91,2 хувьтай хэрэгжсэн дүнтэй байна.

Ийнхүү Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлийн холбогдох заалтуудыг уялдуулан боловсруулсан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд нийт 250 хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдан батлагдснаас

- Нийгмийн бодлогын хүрээнд 49 заалт
- Эдийн засгийн бодлогын хүрээнд 152 заалт
- Төрийн захиргаа, эрх зүйн бодлогын хүрээнд 49 заалтыг амжилттай хэрэгжүүлсэнээр

хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэхэд 91,6 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re5.doc/-оос танилцах

3,2,2 Батламжийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргаас Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийг ханган биелүүлэх талаар тухайн жилийн бодлого зорилт, үйл ажиллагааныхаа төлөвлөлт, шийдвэрт тусган хэрэгжүүлж, хагас бүтэн жилээр явц, үр дүнг тооцон тайланг үнэлгээний хамт Засгийн газарт хүргүүлэн ажилласан байна.

Батламжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээ, эрхлэх асуудлын хүрээний ерөнхий менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж жил бүр дүгнэн ажилласнаар 2010 оны батламжийн хэрэгжилт 99,1 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re7.doc/-оос танилцах

3,2,3 Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзвэл хэрэгжүүлбэл зохих нийт 176 заалтаас 100 хувь бүрэн хэрэгжсэн -5, 80-99 хувьтай хэрэгжиж байгаа -17, 60-79 хувьтай хэрэгжиж байгаа 46, 40-59 хувьтай хэрэгжиж байгаа -80, 20-39 хувьтай хэрэгжиж байгаа 24, 5-19 хувьтай хэрэгжиж байгаа 3 заалт, огт хэрэгжиж эхлээгүй байгаа 1 заалт байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилт үйл ажиллагаа дунджаар 53,8 хувийн биелэлттэй, хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд хийхээр төлөвлөсөн ажил 85,6 хувьтай хэрэгжсэн байна. Хөтөлбөрийг 3 бүлэгт хуваан төлөвлөсөн байгаа бөгөөд нийгмийн бодлогын хүрээнд нийт 45 заалт ажил асуудлыг тусган 53,7 хувьтай, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 91 заалт ажил асуудлыг тусган 53,3 хувьтай, төрийн захиргаа, хууль эрх зүйн бодлогын хүрээнд 40 заалт тусган 60,7 хувьтай хэрэгжүүлж ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилт арга хэмжээг 53,8 хувьтай, 2010 онд хийхээр төлөвлөсөн ажлаа 85,6 хувьтай хэрэгжүүлж ажилласнаас харахад тухайн жилд төлөвлөсөн ажлаа “Хангалттай” хэрэгжүүлсэн байна.

Мөн төлөвлөсөн зарим томоохон ажлууд болох “Нутгийн хишиг” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аймгийн иргэн бүрт 500,000 төгрөг олгох ажил тусгай журмын дагуу хийгдэж эхэлсэн бөгөөд 100 000 төгрөгийг иргэдэд олгосон нь нутгийн баялагаас нутгийн иргэд давуу эрхтэй хүртэх боломжийг нээж өгсөн төдийгүй иргэдээс өндөр үнэлгээ авсан

Хилийн хоёр боомтыг байнгын ажиллагаатай болгосоноор хил худалдааны үеэр иргэдэд тулгамддаг саад бэрхшээлийг арилгасан.

Хөтөлбөрийн хүрээнд аймаг орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодотгож “Байгалийн баялаг-сайн засаглал-хөгжсөн Өмнөговь” хэмээх төлөвлөгөө гаргаж, Монгол улсын хөгжлийн жишиг аймаг болох зорилт тавин ажиллаж эхэлсэн.

Аймгийн төсвийн орлого жил бүр өсөн нэмэгдэж аймаг өөрийгөө бүрэн санхүүжүүлээд зогсохгүй улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг болсон

Орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд уул уурхайн үйлдвэрлэлээс оруулах ашиг орлого нэмэгдэж байгаагийн хэрээр орон нутгийн хөгжил сайжирч байгаа зэрэг ажлыг хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн гол үр дүнтэй ажил болсон байна.

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re8.doc/-оос танилцах

3.2.4 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Тайлант онд Засгийн газрын нийт 112 тогтоол шийдвэрийн 178 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар 89 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Үүнээс Засгийн газрын 103 тогтоолын 147 заалт, Засгийн газрын хурлын 9 тэмдэглэлийн 31 заалтыг хэрэгжүүлсэнээс 79 заалт 100 хувь, 65 заалт 90, 16 заалт 70 хувьтай, 8 заалт 50 хувьтай, 3 заалт 30 хувьтайгаар тус тус хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын тогтоолын 45.3 хувийг бүрэн биелүүлж, 52,4 хувь нь хэрэгжих шатандаа, 1,6 хувь буюу 3 заалт тасарсан дүнтэй байна.

2010 онд батлагдсан тогтоол шийдвэрээс амжилттай хэрэгжүүлсэн байдлаар: 3 дугаар тогтоолын хүрээнд иргэний шинэчилсэн бүртгэлийг хийх, иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах,

2010 оныг Бизнесийн орчны шинэтгэлийн жил болгосон ажлын хүрээнд аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтын гэрээнд бизнесийг дэмжих чиглэлээр 16 асуудал бүхий 7 багц ажлыг тус вн амжилттай хэрэгжүүлсэн, 84 дүгээр тогтоолыг амжилттай хэрэгжүүлж нийт 52212 иргэнийг хамруулсан, 69 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд бүрэн тусган хэрэгжүүлж жилийн эцсийн байдлаар 91,6 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнүүлсэн зэрэг амжилт ололттой ажилласан байна.

Хэрэгжилт нь тасарсан 3 заалт байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 60 хувиар буурсан байна.

Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, хэлтэс, албадын удирдлагуудын удирдлага, зохицуулалтыг сайжруулах, явцын болон дотоодын хяналт, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг өргөтгөн хийсэн нь тодорхой үр дүнд хүрсэн байна.

Дэлгэрэнгүйг /Umnugobi2011Re6.doc/-оос танилцах

3.3 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын талаар

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗДТГ-аас “ Ил тод байдал-чанартай үйлчилгээ” 2 сарын аяныг зохион байгуулж, хяналт тавин биелэлтийг дүгнэж ажилласнаар тогтоолын биелэлт 95,5 хувийн үр дүнд хүрч урьд оноос 6,5 хувиар өссөн байна.

№	Үзүүлэлтийн агуулга	Заалт	Хэрэгжилтийн явц %			Үнэлгээ
			100	90	70	
1	Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал	7	6	1		99,8 % буюу 4,9 оноо
2	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	6	2	3	1	87,5 % буюу 4,4 оноо
3	Төсөв, санхүүгийн ил тод байдал	7	4	3		95,7 % буюу 4,9 оноо
4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	10	9	1		99,0 % буюу 4,9 оноо
5	Дүн	30	21	8	1	95,5 % буюу 4,8 оноо

3,4 Үйл ажиллагааны үр нөлөө, үр дагаврын талаар

3,4,1 Хэрэглэгчийн судалгаа

Төрийн бодлого шийдвэр иргэдийн амьдралд ямар өөрчлөлт гаргасныг судлах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээний дагуу ИНБСүлжээний 9 байгууллагын төлөөлөл оролцсон 4 ажлын хэсэг 15 сумын 56 багийг хамруулан нийт 2569 иргэнээс тусгайлан боловсруулсан саналын хуудсаар үнэлгээ авч, дүгнэсэн байна.

Хэрэглэгчийн үнэлгээгээр аймаг сумдын хэмжээнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд 3,47 гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь хэрэглэгчийн сэтгэл ханамж 2009 оныхоос 0,05%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.

Иргэдээс гарсан санал асуулгыг нэгтгэн үзэхэд 58 төрлийн санал гарснаас судалгаанд оролцогчдын 24,49% нь ажлын байр нэмэгдүүлэх, 8,91% нь цахилгаан дулааны хангалтыг тогтмолжуулах, 6,59% нь эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, 6,12% нь халамжийн үйлчилгээг оновчтой хүргэх, 6,08% нь төрийн үйлчилгээний түргэн шуурхай байдлыг хангах, 5,22% нь нутгийн хишгийн олголтыг хүссэн, 4,36% нь архидалтыг багасгах талаар саналаа ирүүлж, бусад 51 асуудлаар иргэдийн 0,04-2,20% нь санал дүгнэлтээ өгсөн байна.

Санал асуулгын дүнг сум бүрээр гарган аймгийн тэргүүний сум шалгаруулах болзол журмын дагуу хэрэглэгчийн үнэлгээг нэг гол үзүүлэлт болгон сумдын 2010 оны жилийн эцсийн ажлыг дүгнэхэд ашигласан байна.

Хэрэглэгчийн үнэлгээ, судалгаанаас харахд жил бүр иргэд хэрэглэгчидийн сэтгэл ханамжийн түвшин бага хувиар нэмэгдэж байгаа нь иргэд хэрэглэгчдийн сэтгэл ханамж тогтвортой түвшинд байна гэж үзэж болох юм.

ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Засгийн газрын болон аймаг орон нутгийн бодлого шийдвэрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн зэрэгцээ аймаг орон нутгаа хөгжүүлэх 2010 оны эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн аймгийн ИТХ-аас 91,2 хувьтай “Дүүрэн хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. 2011 онд аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтсан 80 бүтээлч ажлын төлөвлөгөө гарган аймаг орон нутгаа хөгжүүлэх, иргэдийнхээ ажиллах амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд иргэд, ААН, төрийн байгууллагуудаа уриалан, бодлого зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын дүнг үндэслэн ажлын хэсгийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Монгол улсын Засгийн газарт:

Улс орны хөгжлийн гол багана болсон төрийн албаны ажил үйлчилгээг сайжруулах, дээшлүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай, орон нутгаас шийдвэрлэх боломжгүй боловч төрийн байгууллагын өмнө тулгамдаж буй хэд хэдэн төрлийн асуудлуудыг энэ дашрамд хүргэе!

Төрийн албанд ашиглаж байгаа өнөөгийн цалин хөлсний тогтолцоог өөрчлөх, мэргэшил ур чадвартаа ахиж дэвшин, тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллаж байгаа төрийн албан хаагчийн цалин хөлсийг байнга нэмэгдүүлэх зарчмын цалин хөлсний тогтолцоог бий болгох

Монгол улсын төрийн албанд үйлчилж байгаа түшмэлийн цол, зэрэг дэв түүнийг олгох, тэдгээрийг дагаж олгогдож байгаа нэмэгдэл урамшлын хувь хэмжээг өөрчлөх

Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийн талаар Засгийн газраас өмнө гаргасан шийдвэрийг дахин авч үзэж, бодит амьдралд нийцүүлэх талаар төрийн албан хаагчдаас санал, шүүмжлэл нийтлэг байдлаар удаа дараа гарч байна. Тухайлбал, Аймгийн Засаг даргын бодлогын мэргэжилтэн “Дэс түшмэл”-ийн зэрэглэлтэй байхад түүний шууд удирдлагад ажиллаж байгаа сумын Засаг даргын Тамгын газрын дарга “Ахлах түшмэл”-ийн зэрэглэлд багтаж байх жишээтэй. Мөн зэрэг

дэвийн нэмэгдэлийн зөрүү нь 1-2 хувь байгаа нь зэрэг дэв ахих сонирхол төрийн албан хаагчдад байхгүй байгаа нь дээрхи дүрэм журмыг эргэж харах шаардлагатай болсныг харуулж байна.

Төрийн захиргааны албан тушаал эрхлэх иргэдэд тавих шалгуур үзүүлэлтийг нарийн тодорхой болгож, журамлах

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг нутгийн захиргааны байгууллагаас хараат бус бие даасан тусгай статустай болгож, захиргааны байгууллагаас хараат байгаа байдлыг арилгах.

Хөдөөгийн алслагдмал сум суурин газрын дэд бүтэц, орчин нөхцөл өнөөгийн залуучуудын хүсэж байгаа шаардлагад хүрэхгүй, тэнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байгаатай холбоотойгоор хөдөө орон нутагт очиж ажиллахыг хүссэн мэргэжилтэй залуусын тоонд бодит ахиц дэвшил гарахгүй байсаар байгаа нь мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагч тэр бүр хөдөө орон нутагт хүрч ажиллахгүй байгаа нь төрийн албаны нэр хүндийг дээшлүүлэх, мэдлэг чадвартай боловсон хүчнээр хөдөө орон нутгийг хангах боломж дутагдалтай байсаар байна.

Уул уурхайн салбар илүүтэй хөгжиж байгаа манай аймгийн хувьд цалин өндөртэй, хангамж сайтай хувийн хэвшилд орж ажиллах сонирхол давамгайлж байгаа бөгөөд харин төрийн албанд ажиллах хүсэлтэй иргэдийн тоо төдийлөн өсөхгүй байгаа хандлага ажиглагдаж байна.

Цаг уурын хүнд хэцүү нөхцөлд ажиллаж амьдарч буй төрийн албан хаагчдад говийн болон алс хязгаар нутгийн нэмэгдэл олгох асуудлыг олон жил судлан ярьж байгаа ч өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байгаа нь мэдлэг чадвартай боловсон хүчин хөдөө нутгийг орхин төв газар шилжих нэг үндэс болж байна.

Төрийн захиргааны албанд тавих ерөнхий болон тусгай шаардлага түүнд тавих хяналт болон хариуцлагын тогтолцоо тодорхой бус байгаагаас сонгон шалгаруулалтад тэнцэж санал болгосон иргэнийг томилохгүй байх зэрэг нийтлэг зөрчил дутагдал хөдөө орон нутагт гарсаар байна.

Тус аймгийн хувьд уул уурхайн салбар эрчимтэй хөгжин хүн амын өсөлт, суурьшил эрс өсч байгаатай холбоотой төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад аймаг, сумын /Цогтцэций, Ханбогд, Гурвантэс/ Засаг даргын Тамгын газрын болон нийгмийн суурь үйлчилгээний байгууллагуудын бүтэц орон тооны асуудлыг зайлшгүй судлан шийдвэрлэх

Орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд төрийн хууль тогтоожид өргөжүүлэх,

Орон нутгийн хөгжилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил асуудлыг тухайн орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай санал солилцон шийдвэрлэж байх */Жич: Дундговь-Даланадгад чиглэлийн хатуу хучилттай зам/*

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхдээ яам, орон нутгийн уялдаа холбоог тодорхой болгох /Улсын хэмжээнд үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилт ихэвчлэн Яамны төсөвт тусгагддаг бөгөөд тэр нь төдийлөн хөдөө орон нутагт хүрдэггүй гэсэн ойлголт байгаа/

Хөдөө орон нутагт төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх, анхан шатны төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд гол саад болж байгаа дээрх асуудлуудыг орон нутагт бодитой, ажил хэрэгчээр шийдвэрлэхэд төр, засгийн удирдах дээд байгууллагын бодлого, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна

Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг төрийн албаны шинэтгэл, Засгийн газрын болон аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, шийдвэр, өнөөгийн шаардлага, нөхцөлтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх

Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ажлын хариуцлага, багаар ажиллах чадвар, хэлтэс албадын ажлын уялдаа холбоог сайжруулах

Төрийн байгууллагын үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд аймгийн ВЭБ сайт, дотоод сүлжээний ашиглалт, мэдээллийн давтамж, чанарыг аймаг сумын түвшинд дээшлүүлэх

Төрийн албаны стандарт хангалтыг сайжруулах чиглэлээр албан хаагчдын дотоодод зохион байгуулах сургалт сурталчилгааг нэмэгдүүлэх

Төрийн албанд анх орох иргэний сонгон шалгаруулалтыг зарлах, зохион байгуулахдаа “Ажлын байрны тодорхойлолт”-д тавигдаж байгаа шаардлагыг илүү нарийн, тухайн албан тушаалыг эрхлэхэд шаардлагатай мэдлэг чадвар, боловсрол, ёс зүйтэй иргэнийг сонгон шалгаруулж авахад

чиглэгдсэн байдлаар тодорхойлж байх, энэ чиглэлээр удирдах албан тушаалтнуудыг сургаж дадлагажуулах

Төрийн жинхэнэ албанд анх удаа орж байгаа иргэнд туршилтын хугацааг заавал хэрэглэж байх.

Төрийн захиргааны албаны ёс зүй, албан хаагчдын биеэ авч явах соёл хандлагын талаар ном сурах бичиг, гарын авлага материал бэлтгэн төрийн байгууллагуудад хүргэж сурталчилах

Төрийн албанд орж ажиллах хүсэл сонирхолтой иргэдэд төрийн алба эрхлэхэд шаардлагатай мэдлэг олгох энэ чиглэлээр ажил эрхлэх төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллах

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАСГИЙН

ДАРГА

Г.ХАНДАРМАА

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Ш.БАТ-ЭРДЭНЭ